

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/40/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа

Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5.1. Албан шаардлага	21
5.2 Зөвлөмж	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДҮЗ	Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл
НДЕГ	Нийгмийн даатгалын Ерөнхий газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.03.25 № 2/93
танай _____-ны № _____-т

**БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.АЗЖАРГАЛ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тайлант хугацаанд дараах онцлог үйл явдал болсон байна. Үүнд:

- Улсын Их хурлын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн чуулганаар баталсан Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн "Итгэлцүүр шинэчлэн батлах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 238 дугаар болон "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 239 дугаар тогтоолоор итгэлцүүрийг шинэчлэн баталж, үүний дагуу тэтгэвэр тогтоолгосон

5020353

- иргэдийн цалинг шинэчлэн тооцсон;
- Улсын Их хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр чуулганаар Нийгмийн даатгалын багц хуулийг шинэчлэн баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр заажээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдийн А/196 дугаар тушаалаар Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны ажлын үр дүнг 85.4 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,848,376.3	11,353,771.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,022,804.4	7,957,845.9
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,022,804.4	7,957,845.9
31210	Төгрөг	6,022,804.4	7,957,845.9
31211	Төрийн сангийн харилцах	0.0	0.0
31213	Арилжааны банк дахь харилцах	6,022,804.4	7,957,845.9
33	АВЛАГА	4,808,285.6	3,361,759.9
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,468,518.2	1,997,318.6
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,206,782.2	1,322,505.2
33500	Бусад авлага	132,985.2	41,936.2
33510	Байгууллагаас авах авлага	132,648.8	41,936.2
33520	Хувь хүмүүсээс авах авлага	336.4	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	17,286.3	34,165.2
35400	Хангамжийн материал	17,286.3	34,165.2
35410	Бичиг хэргийн материал	1,279.0	2,634.0
35420	Аж ахуйн материал	11,998.0	27,093.0
35430	Сэлбэг хэрэгсэл	2,932.5	3,437.5
35470	Бусад хангамжийн материал	1,076.9	1,000.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	268,068.3	256,693.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	268,068.3	256,693.5
39200	Биет хөрөнгө	130,843.3	119,468.5
39201	Барилга, байгууламж, орон сууц	466,812.1	466,812.1
39202	Хуримтлагдсан элэгдэл	-446,652.8	-449,029.7
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,980.0	89,980.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-89,980.0	-89,980.0
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	180,745.4	128,591.5
39206	Хуримтлагдсан элэгдэл	-85,599.7	-41,633.2
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,291.4	55,860.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-40,753.0	-44,620.3
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.0	3,488.0
39300	Биет бус хөрөнгө	137,225.0	137,225.0
39301	Програм хангамж	3,700.6	3,700.6
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,700.6	-3,700.6
39303	Бусад биет бус хөрөнгө	137,225.0	137,225.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,116,444.6	11,610,464.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	479,517.8	581,552.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	479,517.8	581,552.9
41300	Өглөг	134,507.2	52,063.1
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	134,507.2	52,063.1
41400	Урьдчилж орсон орлого	345,010.5	529,489.7
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	345,010.5	529,489.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,636,926.8	11,028,911.6
51	Засгийн газрын хувь оролцоо	10,636,926.8	11,028,911.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	320,944.7	320,944.7
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	320,944.7	320,944.7
51200	Хуримтлагдсан үр дүн	10,096,527.4	10,488,512.2
51210	Өмнөх үеийн үр дүн	10,705,546.9	10,095,608.6
51220	Тайлант үеийн үр дүн	-609,019.5	392,903.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	219,454.7	219,454.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,116,444.6	11,610,464.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	90,789,784.51	99,991,076.77
11	ТАТВАРЫН ОРЛОГО	29,845,216.88	38,403,937.76
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	29,845,216.88	38,403,937.76
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	20,905,615.92	26,869,932.15
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,163,535.34	2,786,664.56
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,327,806.46	1,686,164.50
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	393,936.00	512,501.83
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,054,323.16	6,548,674.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	107,255.44	133,889.63
120	Нийтлэг татварын бус орлого	107,255.44	133,889.63
120002	Хүүгийн орлого	0	52,445.99
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,213.24	11,488.02
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,158.24	11,488.02
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	55.00	0
120009	Бусад орлого	27,492.21	55,724.91
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	70,550.00	14,230.71
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	60,837,312.19	61,453,249.38
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,611,455.40	8,361,899.43
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,611,455.40	8,361,899.43
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,000.00	0
1330	Төсвийн захирагчдаас	52,499,667.99	51,866,591.55
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,499,667.99	51,866,591.55
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	710,188.80	1,224,758.40
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	702,124.70	1,224,758.40
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	8,064.10	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	91,398,804.01	99,598,173.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	91,398,804.01	99,598,173.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	721,055.81	1,189,638.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	533,982.41	932,161.97
210101	Үндсэн цалин	396,118.40	537,703.67
210102	Нэмэгдэл	85,383.90	255,361.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,580.80	46,173.60
210104	Урамшуулал	18,899.32	92,923.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,786.82	115,627.38
210201	Тэтгэврийн даатгал	45,279.30	78,585.31
210202	Тэтгэмжийн даатгал	5,380.83	9,407.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,304.68	7,597.65
210204	Ажилгүйдлийн даатгал	1,085.70	1,844.13
210205	Эрүүл мэндийн даатгал	10,736.30	18,192.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,587.53	43,057.55
210301	Гэрэл, цахилгаан	3,177.48	3,665.34
210302	Түлш, халаалт	29,619.15	35,542.98
210303	Цэвэр, бохир ус	3,790.90	3,849.23
2104	Хангамж, бараа материалын зардал	22,950.61	34,920.70
210401	Бичиг хэрэг	4,800.83	15,741.10
210402	Тээвэр, шатахуун	9,475.60	7,253.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,109.45	5,251.55

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400.00	600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,164.73	5,849.80
210408	Бараа материал акталсны зардал	0	225.14
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,441.00	4,199.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	441.00	398.00
210604	Урсгал засвар	19,000.00	3,801.00
2107	Томилолт, зочны зардал	2,264.00	11,668.00
210702	Дотоод албан томилолт	2,264.00	11,668.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,678.13	18,009.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,862.50	8,188.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000.00	1,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	800.00	800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98.10	177.00
210807	Газрын төлбөр	302.73	325.40
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,470.14	6,326.39
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,144.67	1,193.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,365.31	29,993.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,365.31	29,093.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,677,748.20	98,408,535.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,184,668.38	90,312,647.87
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	78,176,831.38	90,278,723.47
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,837.00	9,397.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	24,527.40
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,493,079.83	8,095,887.17
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,493,079.83	8,095,887.17
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-609,019.50	392,903.64
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-609,019.50	392,903.64

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	91,071,344.82	102,062,457.18
11	ТАТВАРЫН ОРЛОГО	29,338,575.74	37,978,941.65
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	29,338,575.74	37,978,941.65
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	20,563,176.55	26,584,320.83
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,129,556.75	2,754,960.60
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,302,335.51	1,665,795.50
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	384,913.90	504,802.01
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	4,958,593.03	6,469,062.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	156,368.08	518,947.68
120	Нийтлэг татварын бус орлого	156,368.08	518,947.68
120002	Хүүгийн орлого	0	46,523.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	155,728.08	472,087.79
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	155,673.08	472,087.79
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	55.00	0
120009	Бусад орлого	640.00	336.41
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	61,576,401.00	63,564,567.85
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,413,106.30	10,476,235.70

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,413,106.30	10,476,235.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,000.00	0
1330	Төсвийн захирагчдаас	52,437,105.90	51,863,573.75
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,437,105.90	51,863,573.75
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	710,188.80	1,224,758.40
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	702,124.70	1,224,758.40
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	8,064.10	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	91,558,766.30	100,123,927.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	91,558,766.30	100,123,927.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	712,163.51	1,174,916.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	534,082.41	932,161.97
210101	Үндсэн цалин	396,218.40	537,703.67
210102	Нэмэгдэл	85,383.90	255,361.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,580.80	46,173.60
210104	Урамшуулал	18,899.32	92,923.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,786.82	116,044.67
210201	Тэтгэврийн даатгал	45,279.30	79,002.60
210202	Тэтгэмжийн даатгал	5,380.83	9,407.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,304.68	7,597.65
210204	Ажилгүйдлийн даатгал	1,085.70	1,844.13
210205	Эрүүл мэндийн даатгал	10,736.30	18,192.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,493.63	43,151.45
210301	Гэрэл, цахилгаан	3,177.48	3,665.34
210302	Түлш, халаалт	29,619.15	35,542.98
210303	Цэвэр, бохир ус	3,697.00	3,943.13
2104	Хангамж, бараа материалын зардал	23,597.81	49,469.95
210401	Бичиг хэрэг	5,237.83	15,513.30
210402	Тээвэр, шатахуун	9,475.60	7,253.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,109.45	5,251.55
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400.00	600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,374.93	20,852.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,405.40	4,704.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,405.40	903.00
210604	Урсгал засвар	19,000.00	3,801.00
2107	Томилолт, зочны зардал	2,264.00	11,668.00
210702	Дотоод албан томилолт	2,264.00	11,668.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,533.44	16,816.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,862.50	8,188.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000.00	1,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	800.00	800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98.10	177.00
210807	Газрын төлбөр	302.70	325.43
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,470.14	6,326.39
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,846,602.79	98,949,010.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,353,522.96	90,853,123.71
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	78,176,831.38	90,278,723.47

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,837.00	9,397.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	168,854.58	540,475.85
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	24,527.40
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,493,079.83	8,095,887.17
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,493,079.83	8,095,887.17
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-487,421.47	1,938,529.44
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	3,488.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	3,488.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	3,488.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	3,488.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	-3,488.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-487,421.47	1,935,041.44
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,510,225.88	6,022,804.41
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,022,804.41	7,957,845.85

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,944.66	219,454.71	10,705,546.95	11,245,946.32
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-0.00004	-0.00004
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	320,944.66	219,454.71	10,705,546.95	11,245,946.32
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-609,019.50	-609,019.50
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,944.66	219,454.71	10,096,527.45	10,636,926.82
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	320,944.66	219,454.71	10,096,527.45	10,636,926.82
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-918.85	-918.85
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	320,944.66	219,454.71	10,095,608.59	10,636,007.96
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	392,903.64	392,903.64
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,944.66	219,454.71	10,488,512.23	11,028,911.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	96,463,968.1	91,491,052.7	4,972,915.4	94.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	96,463,968.1	91,491,052.7	4,972,915.4	94.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,199,765.2	1,178,404.9	21,360.3	98.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	943,046.2	932,162.0	10,884.2	98.8
210101	Үндсэн цалин	538,026.0	537,703.7	322.3	99.9
210102	Нэмэгдэл	255,361.7	255,361.7	0.0	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,173.6	46,173.6	0.0	100.0
210104	Урамшуулал	103,484.9	92,923.0	10,561.9	89.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,401.6	116,044.7	3,356.9	97.2
210201	Тэтгэврийн даатгал	81,193.1	79,002.6	2,190.5	97.3
210202	Тэтгэмжийн даатгал	9,552.1	9,407.3	144.8	98.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,641.7	7,597.6	44.1	99.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,910.5	1,844.1	66.4	96.5
210205	Эрүүл мэндийн даатгал	19,104.2	18,193.0	911.2	95.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,077.1	43,151.4	925.7	97.9
210301	Гэрэл, цахилгаан	4,283.5	3,665.3	618.2	85.6
210302	Түлш, халаалт	35,543.0	35,543.0	0.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	4,250.6	3,943.1	307.5	92.8
2104	Хангамж, бараа материалын зардал	50,161.2	49,470.0	691.2	98.6
210401	Бичиг хэрэг	15,513.3	15,513.3	0.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	7,943.5	7,253.1	690.4	91.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,252.4	5,251.6	0.8	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600.0	600.0	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,852.0	20,852.0	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,194.4	8,192.0	2.4	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	905.4	903.0	2.4	99.7
210604	Урсгал засвар	7,289.0	7,289.0	0.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	11,708.1	11,668.0	40.1	99.7
210702	Дотоод албан томилолт	11,708.1	11,668.0	40.1	99.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,276.6	16,816.8	5,459.8	75.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,550.0	8,188.0	2,362.0	77.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000.0	1,000.0	0.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	800.0	800.0	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200.0	177.0	23.0	88.5
210807	Газрын төлбөр	650.0	325.4	324.6	50.1
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,076.6	6,326.4	2,750.2	69.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	900.0	900.0	0.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900.0	900.0	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	95,264,202.9	90,312,647.9	4,951,555.0	94.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,264,202.9	90,312,647.9	4,951,555.0	94.8
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	95,230,275.5	90,278,723.5	4,951,552.0	94.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,400.0	9,397.0	3.0	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,527.4	24,527.4	0.0	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	96,463,968.1	42,098,140.6	54,365,827.5	43.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,476,235.7	10,476,235.7	0.0	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	10,476,235.7	10,476,235.7	0.0	100.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	85,987,732.4	31,554,919.3	54,432,813.1	36.7
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	85,987,732.4	31,554,919.3	54,432,813.1	36.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.0	66,985.6	-66,985.6	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	66,985.6	-66,985.6	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	6,022,804.4	-6,022,804.4	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	7,957,845.9	-7,957,845.9	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	44	40	4.00	90.9
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0

620002	Гүйцэтгэх ажилтан	37	34	3.00	91.9
620003	Үйлчлэх ажилтан	6	5	1.00	83.3
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	44	40	4.00	90.9
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	38	33	5.00	86.8
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	7	-1.00	116.7

3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь "Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ" эрхэм зорилготой үндсэн 39, гэрээт ажилтан 1, нийт 40 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг 2023 оны 1-2 дугаар сард Б.Баярсайхан, 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хойш даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Б.Азжаргал, 2 дугаар гарын үсгийг Санхүү, бүртгэлийн тасгийн дарга, ахлах нягтлан бодогч С.Хонгорзул нар зурж, нярваар У.Өлзийбаяр 1-7 сар болон 12 дугаар сард ажиллан Ч.Золзаяа 8-11 дүгээр саруудад ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Улсын Их хурлын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн чуулганаар баталсан Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн "Итгэлцүүр шинэчлэн батлах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 238 дугаар болон "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 239 дугаар тогтоолоор итгэлцүүрийг шинэчлэн баталж, үүний дагуу тэтгэвэр тогтоолгосон иргэдийн цалинг шинэчлэн тооцсон'
- Улсын Их хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр чуулганаар Нийгмийн даатгалын багц хуулийг шинэчлэн баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр заажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй НДЕГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/64 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 494,019.9 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,022,804.4	7,957,845.9	1,935,041.4
Авлага	4,808,285.6	3,361,759.9	(1,446,525.6)
Бараа материал	17,286.3	34,165.2	16,878.9
Үндсэн хөрөнгө	934,754.5	885,657.2	(49,097.3)
Хуримтлагдсан элэгдэл	-666,686.18	(628,963.7)	37,722.4
Нийт хөрөнгө	11,116,444.6	11,610,464.5	494,019.9
Өр төлбөр	479,517.8	581,552.9	102,035.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	10,636,926.8	11,028,911.6	391,984.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,116,444.6	11,610,464.5	494,019.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн тайлан

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,022,804.4 мянга, эцсийн үлдэгдэл 7,957,845.8 мянган төгрөг болж 1,935,041.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	0	0	0	0
Төрийн сан дахь харилцах	0	0	0	0
Банканд байгаа бэлэн мөнгө	6,022,804.4	7,957,845.8	1,935,041.4	100.0
Төвлөрсөн сан	2,974.0	60,099.7	57,125.7	0.76
Тэтгэврийн даатгалын сан	5,893,071.3	7,743,052.1	1,849,980.8	97.30
Тэтгэмжийн даатгалын сан	76,396.3	73,189.6	(3,206.7)	0.92
ҮОМШӨ даатгалын сан	25,273.8	65,904.4	40,630.6	0.83
ЭМД-ын сан	127.4	1,442.6	1,315.2	0.02
Ажилгүйдлийн даатгалын сан	24,961.7	14,157.4	(10,804.3)	0.2
Дүн	6,022,804.4	7,957,845.8	1,935,041.4	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн тайлан

Арилжааны банкны үлдэгдлийн 97.3 хувь буюу 7,743,052.1 мянган төгрөг нь тэтгэврийн даатгалын сан байгаа нь дараа сарын тэтгэвэр, тэтгэмжийг олгохоор санхүүжилтийг өмнөх сард олгосонтой холбоотой байна.

Төвлөрсөн сан болон эрүүл мэндийн даатгалын санд оны эцэст интернэт банкаар гүйлгээ орсноос шалтгаалж, оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 3. Сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Банк	Төвлөрсөн харилцах	Тэтгэвэр	Тэтгэмж	ҮОМШӨ	ЭМД	Ажилгүйдэл	Дүн
Голомт банк	13.7	240,914.7	0	0	0	0	240,928.4
Төрийн банк	2,962.7	2,924,119.5	57,492.8	52,513.3	59.7	5,215.6	3,042,363.4
Хаан банк	57,097.2	4,578,018.0	15,696.7	13,391.1	1,373.0	8,941.8	4,674,517.7
Хасбанк	26.2	-	-	-	10.0	-	36.2
Дүн	60,099.7	7,743,052.1	73,189.6	65,904.4	1,442.6	14,157.4	7,957,845.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн харилцахын үлдэгдэл

Арилжааны банканд байршиж байгаа мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс харахад нийт үлдэгдлийн 58.7 хувь буюу 4,674,517.7 мянган төгрөг нь Хаан банканд, 38.2 хувь буюу 3,042,363.4 мянган төгрөг нь Төрийн банканд байршсан байна.

3.4.2. Авлага

Оны эхний 4,808,285.6 мянган төгрөгийн авлага 1,446,525.6 мянган төгрөгөөр буурч оны эцэст 3,361,759.9 мянган төгрөгийн авлагатай гарчээ.

Хүснэгт 4. Сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төлбөртэй үйлчилгээний авлага	1,468,518.2	1,997,318.6	528,800.4	59.4
Татаас санхүүжилтийн авлага	3,206,782.2	1,322,505.2	(1,884,277.0)	39.3
Бусад авлага	132,985.2	41,936.2	(91,049.0)	1.2
Байгууллагаас авах авлага	132,648.8	41,936.2	(90,712.6)	
Хувь хүмүүсээс авах авлага	336.4	-	(336.4)	
Дүн	4,808,285.6	3,361,759.9	(1,446,525.6)	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн тайлан

Нийгмийн даатгалын сан

Төлбөрт үйлчилгээний авлага оны эхний үлдэгдэл 1,468,518.2,2 мянга төгрөг 528,800.4 мянган төгрөгөөр өсөж оны эцэст 1,997,318.6 мянган төгрөг болсон нь 432 аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байна.

Оны эхэнд 230 ажил олгогчоос 1,468,518.2 мянган төгрөгийн авлагатай байсан, үйл ажиллагаа нь зогссоноос хуримтлагдсан авлага үүссэн 81 аж ахуйн нэгжийн 261,000.0 мянган төгрөгөөс 29 аж ахуйн нэгжийн 56,725.0 мянган төгрөгийн төлбөрийг гэрээний дагуу төлөлт хийлгэн, урьд оны авлагаас 165 аж ахуйн нэгжийн 811,441.0 мянган төгрөгийг барагдуулжээ.

Татаас санхүүжилтийн авлага өмнөх оноос 1,884,227.0 мянган төгрөгөөр буурч 1,322,505.2 мянган төгрөг болсон нь Коронавируст халдвар /COVID/ 2020 онд гарснаас шалтгаалан үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурсан хэдий ч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчаас бусад даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан ажил олгогч болон даатгуулагчийн 2020 оны 4-10 дугаар саруудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлснийг тайлант онд улсын төсвөөс олгосонтой холбоотой тус авлага буурчээ.

Хүснэгт 5. Татаас санхүүжилтийн авлагын үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Даатгуулагчийн тоо	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Аж ахуйн нэгж, байгууллага	383	1,585,232	-	(1,585,232)	-
Сайн дурын даатгуулагч	6555	1,314,350	1,015,305	(299,045)	76.8
Ажилгүйдлийн дэмжлэг	49	307,200	307,200	-	23.2
Дүн	6987	3,206,782	1,322,505	(1,884,277)	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн тайлан

Байгууллагаас авах авлага оны эхний үлдэгдэл 132,648.8 мянга, оны эцсийн үлдэгдэл 41,936.2 мянган төгрөг байгаа ба тус авлага нь тэтгэврийн даатгалын сангаас сумдад олгохдоо тэтгэмжийн даатгалын санд сан андуурч гүйлгээ хийсэнтэй холбоотой авлага болно.

Нийгмийн даатгалын хэлтэс

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь оны эхэнд дарга асан Ц.Сэмжиддоржтой холбоотой 336.4 мянган төгрөгийн авлагатай байсныг барагдуулж, тайланд хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн 417.3 мянган төгрөгийн авлага нэмэгдсэн байна.

3.4.3. Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 17,286.3 мянга, эцсийн үлдэгдэл 34,165.2 мянган төгрөг болж, 16,878.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Бичиг хэргийн материал	1,279.0	2,634.0	1,355.0	7.7
Аж ахуйн материал	11,998.0	27,092.9	15,094.9	79.3
Сэлбэг хэрэгсэл	2,932.4	3,437.5	505.1	10.1
Бусад хангамжийн материал	1,076.9	1,000.8	(76.1)	2.9
Дүн	17,286.3	34,165.2	16,878.9	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн тайлан

Аж ахуйн бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 15,094.9 мянган төгрөгөөр нэмэгдэн 27,092.9 мянган төгрөг болсон нь байгууллагын нэр Нийгмийн даатгалын газар болон өөрчлөгдөж, 14,430.0 мянган төгрөгөөр байгууллагын дотор, гадна талын хаягийг шинэчлэн хийлгэж, бараа материалын үлдэгдлээр тайлагнасан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

3.4.4. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө өмнөх оноос 49,097.3 мянган төгрөгөөр буурч 885,657.2 мянган төгрөг болсон ба нийт үндсэн хөрөнгийн 52.7 хувийг барилга байгууламж эзэлж байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Барилга байгууламж, орон сууц	466,812.1	466,812.1	-	52.7
Тээврийн хэрэгсэл	89,980.0	89,980.0	-	10.2
Машин тоног төхөөрөмж	180,745.4	128,591.5	(52,153.9)	14.5
Тавилга эд хогшил	56,291.4	55,860.0	(431.4)	6.3
Программ хангамж	3,700.6	3,700.6	-	0.4
Бусад биет бус хөрөнгө	137,225.0	137,225.0	-	15.5
Дуусаагүй үйлдвэрлэл	-	3,488.0	3,488.0	0.4
Дүн	934,754.5	885,657.2	(49,097.3)	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө худалдаж аваагүй, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 116 дугаар тогтоолоор Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын ашиглаж байсан 3,880.9 мянган төгрөгийн 7 нэр төрлийн үндсэн хөрөнгө шилжиж ирсэн, НДЕГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/200 дугаар тушаалаар 70,582.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актлан данснаас хасан, хассан үндсэн хөрөнгөд үнэ болон ашиглах жилийн шинэчлэн тогтоосноор 14,116.5 мянган төгрөгийн хөрөнгийг эргэн орлогод авсан нь нөлөөлсөн байна.

Аудитаар тус байгууллагын барилгыг шинээр барихтай холбоотой холбогдох байгууллагуудаар техникийн нөхцөл гаргуулах зардалд 3,488.0 мянган төгрөгийн төлж, тайлант жилийн зардлаар тайлагнасан зөрчил илэрснийг санхүүгийн тайланд Дуусаагүй үйлдвэрлэл дансанд залруулсан болно.

3.4.5. Өр төлбөр

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 479,517.8 мянга, эцсийн үлдэгдэл 52,063.1 мянган төгрөг болж, 102,035.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Бараа үйлчилгээний зардлын өглөг	134,507.2	52,063.1	(82,444.1)	9.0
Урьдчилж орсон орлого	345,010.5	529,489.7	184,479.2	91.0
Дүн	479,517.8	581,552.8	102,035.0	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн тайлан

Бараа үйлчилгээний өглөг тайлант онд 82,444.1 мянган төгрөгөөр буурсан нь аймгаас сумд руу сайн дурын даатгуулагч эхийн тэтгэмжийн даатгалын сангаас олгосон шитгэлийг авлага, сум хооронд төвлөрүүлсэнтэй холбоотой үүссэн байна.

Харин урьдчилж орсон орлогын эхний үлдэгдлийн 345,010.5 мянган төгрөг 184,479.2 мянган төгрөгөөр нэмэгдэж 529,489.7 мянган төгрөг болсон ба үүнээс 28,586.9 мянган төгрөг нь ажил олгогч байгууллагаас төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого бол 316,425.5 мянган төгрөг нь сайн дурын даатгуулагчаас төлсөн нийгмийн даатгалын шимтгэл байна. Сайн дурын даатгуулагчийн хувь шимтгэлээ жилээр гэрээ хийж ноос ноолуурын үеэр шимтгэлийн орлого урьдчилж төлсөнтэй холбоотой үүсжээ.

3.4.6. Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 10,636,926.8 мянга, эцсийн үлдэгдэл 11,028,911.6 мянган төгрөг болж, 391,984.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	320,944.7	320,944.7	-	2.9
Хуримтлагдсан үр дүн	10,096,527.4	10,488,512.2	391,984.8	95.1
Өмнөх үеийн үр дүн	10,096,527.4	10,095,608.6	(918.8)	
Тайлант үеийн үр дүн	-	392,903.6	392,903.6	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	219,454.7	219,454.7	-	2.0
Дүн	10,636,926.8	11,028,911.6	391,984.8	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн тайлан

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Хяналт, шалгалт, дотоод аудитаар 2022 онд зогсоосон тэтгэвэрт хийсэн шалгалтаар нас барсан 6 иргэнд 918,8 мянга төгрөгийн тэтгэврийг нөхөн олгосонтой холбоотой өмнөх үеийн үр дүн буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн төслийг 100,303,573.8 мянга, үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн төслийг 885,582.4 мянган төгрөгөөр баталж, НДЕГ-т албан бичгээр хүргүүлсэн байна.

НДЕГ нь Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны урсгал зардлыг төсвийн төслөөс 111,958.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 997,541.4 мянган төгрөгөөр баталсан нь цалингийн зардал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

Харин нийгмийн даатгалын сангийн төсвийг төсвийн төслөөс 13,017,053.2 мянган төгрөгөөр бууруулан 87,286,520.6 мянган төгрөгөөр баталсан нь 07 дугаар сараас нэмэгдэх тэтгэврийн хэмжээг 01 дүгээр сараас эхлэн тооцоолсонтой холбоотой бууруулан баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Оны эхэнд баталсан төсвийг НДЕГ-ын даргын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/90 дугаар тушаалаар 7,957,226.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь тэтгэврийн нэмэгдлийг тооцсонтой холбоотой бөгөөд НДҮЗ-ийн 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 03 дугаар тогтоолоор 193,654.9 мянга, 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 14 дугаар тогтоолоор 29,025.0 мянган төгрөгөөр урсгал зардлыг нэмэгдүүлж, нийт төсвийг 96,463,968.1 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71901 (Нийгмийн даатгал) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 1,224,758.4 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, гүйцэтгэлээр Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны зардалд 1,206,145.3 мянган төгрөгийг зарцуулж, зардлын хэмнэлтийн 18,613.1 мянган төгрөгийг оны эцэст НДЕГ-т төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	943,046.2	932,162.0	10,884.2
2	Ажил олгогчоос төлөх НДШ	119,401.6	116,044.7	3,356.9
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,077.1	43,151.4	925.7
4	Хангамж бараа материалын зардал	50,161.2	49,470.0	691.2
5	Эд хогшил, урсгал засварын зардал	8,194.4	8,192.0	2.4
6	Томилолт, зочны зардал	11,708.1	11,668.0	40.1
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,342.4	10,632.8	2,709.6
8	Бараа үйлчилгээний бусад зардал	900.0	900.0	-
9	Урсгал шилжүүлэг	33,927.4	33,924.4	3.0
	ДҮН	1,224,758.4	1,206,145.3	18,613.1

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн төсвийн хэлбэлзэл

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийг 95,230,275.5 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 90,278,723.5 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг олгосон байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Тэтгэврийн даатгалын сан	90,552,896.4	85,917,152.5	4,635,743.9	95%
2	Тэтгэмжийн даатгалын сан	3,631,882.9	3,237,620.7	394,262.2	89%
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	287,017.3	254,357.5	32,659.8	89%
4	Ажилгүйдлийн даатгалын сан	758,478.9	869,592.8	(111,113.9)	115%
	ДҮН	95,230,275.5	90,278,723.5	4,951,552.0	95%

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн төсвийн хэлбэлзэл

Тайлант онд ажилгүйдлийн даатгалын сангаас бусад сан баталсан төсвийн хүрээнд олгосон бол ажилгүйдлийн даатгалын сангийн баталсан төсвийг 111,113.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосныг тэтгэврийн даатгалын сангаас олгосон байгаа бөгөөд энэ талаар тодруулахад тухайн оны сангийн баталсан төсөвт багтаан гүйлгээ хийсэн гэсэн тайлбарыг шалгагдагч байгууллагаас өгсөн болно.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4. Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс баталсан төсвийн хүрээнд тавьсан зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж, хөтөлбөрийн үр дүнг дараах байдлаар тайлагнасан байна.

Хүснэгт 12. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Тэтгэвэр тэтгэмжийг хуулийн хугацаанд олгосон байх	Өндөр насны тэтгэвэр, тахир дутуугийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, цэргийн тэтгэвэр авагч нийт 13,166 тэтгэвэр авагчдад хуулийн хугацаанд тэтгэврийг олгосон.	90,552,896.40	85,917,152.54
2	Тэтгэмжийг хуулийн хугацаанд олгосон байх	Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмжийг 476, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг 1178, оршуулгын тэтгэмжийг 295, нийт 2049 даатгуулагчид тэтгэмжийг хуулийн хугацаанд нь олгосон.	3,631,882.90	3,237,620.70
3	Тэтгэвэр, тэтгэмжийг хуулийн хугацаанд олгосон байх	Тахир дутуугийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 26 иргэнд тэтгэвэр, тэтгэмжийг хуулийн хугацаанд нь олгосон.	287,017.30	254,357.47
4	Тэтгэмжийг хуулийн хугацаанд олгосон байх	Ажилгүйдлийн тэтгэмжийг 327 даатгуулагчид олгосон.	758,478.90	869,592.76

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээлэл

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн албан хаагчдын цагийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.10.24-ний өдрийн 01/371 дүгээр албан бичгээр

ирүүлж, санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг 2024.03.05-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн 96,463.968.1 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 482,344.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 289,406.9 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 111 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, дараа жилийн төсвийг төслийг хугацаа хоцроож байршуулсан, харин Нийгмийн даатгалын хэлтсийн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 109 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хоцроож мэдээлсэн байна.

Тус байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын даргын 2 тушаал, тайлант онд байгуулсан 1 гэрээг мэдээлээгүй зөрчил аудитаар илэрч, албан шаардлага өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, санхүүгийн тайланд 332.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулан, 1,895.2 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд 853.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,042.1 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 13. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	853.1	1	853.1	100
Албан шаардлага	1	1,042.1	1	1,042.1	100

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2023.06.28-ны өдрийн 01/270 дугаар албан бичиг

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн тухай хуульд заасан аудитыг гүйцэтгэх хугацаа богино, аудитыг нэг аудитор гүйцэтгэсэн зэргээс шалтгаалж, Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд санхүүгийн тайлангийн аудитыг бүрэн хамруулаагүй, ажилгүйдлийн тэтгэмжийн зардалд түүврийн аргаар аудит гүйцэтгэсэн тул дараагийн аудитаар нийгмийн даатгалын сангийн зарцуулалтыг тодруулан үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 13,447.8 мянган төгрөгийн дараах 2 алдаа илэрч, аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

1. Хэлтсийн барилгыг ирэх онд шинээр барихтай холбоотой цэвэр бохир ус, халаалт, холбоо, эрчим хүчний техникийн нөхцөл гаргуулах зардалд 3,488.0 мянган төгрөгийг олгож, бараа материалд орлогоор бүртгэж, зардлаар тайлагнасан байна.

Энэ нь УСНББОУС-ийн УСНББОУС-17 дахь 31 (е)т заасан “Үндсэн хөрөнгийн зүйлийн өртөг нь дараах зүйлсээс бүрдэнэ: шууд хамааралтай өртөг: мэргэжлийн үйлчилгээний хөлс”, Төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журмын 8.1-т заасан “Үйлдвэрлэлд ашиглах түүхий эд материал, үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулах хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа, худалдан борлуулах, хуваарилах зорилгоор эзэмшиж байгаа, борлуулах буюу хуваарилахын тулд үйлдвэрлэлийн дамжлагад байгаа хөрөнгө бараа материалд хамрагдана”, 10.12-т заасан “Байгууллага өөрөө барьж байгуулж байгаа үндсэн хөрөнгийн өртөгт барилгыг барьж, ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэл гарсан бүх зардал багтана” гэсэн заалтыг зөрчсөн, Ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Дуусаагүй барилга байгууламж дансанд аудитаар залруулсан.

2. Бараа материалыг актлах шийдвэр гараагүй байхад тайлант онд 9,959.8 мянган төгрөгийн бараа материалыг акталсан, устгалын акт байхгүй, тухайн бараа материалыг актлах А/05 дугаар шийдвэрийг 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтуудыг зөрчсөн, Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн тайланд бараа материалын үлдэгдлээр залруулав.

Аудитаар нийт 69,623.9 мянган төгрөгийн 4 зөрчил¹ илэрснээс 69,623.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өглөө. Тухайн байгууллагын үндсэн хөрөнгөд тайлант онд өөрчлөлт ороогүй тул бараа материалын үлдэгдлийн 24,205.4 мянган төгрөгөөр зөрчлийн дүнг тооцож, тооллогын ажлын хэсгийг хангалтгүй ажилласан гэж дүгнэв.

5.1. Албан шаардлага

1. Байгууллагын дарга хэлтсийн үндсэн хөрөнгө, бараа материалын 2023 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэгт үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогчийг томилсон, ажлын хэсгийн бэлтгэсэн тооллогын бүртгэл хийсэн ажлын баримт хангалтгүй, тооллогын дүнг баталгаажуулсан тушаал гаргаагүй, албан хаагчдын эд хөрөнгийн картыг шинэчлэн хөтөлж албажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараахь бэлтгэл хангасан байх үүрэгтэй: бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх”, 72 дугаар зүйлийн 72.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна”, 72.4 дэх “Тооллогын комисс дараахь үүрэгтэй: комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хийж ажлын хэсгийг хуульд нийцүүлэн томилж, хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэж, албан хаагчдын эд хөрөнгийн картыг шинэчлэн албажуулах албан шаардлагыг хүргүүлэв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын даргын урамшуулал олгох тухай 39,782.0 мянган төгрөгийн А/17, А/20 дугаар тушаалууд, тайлант онд “Их номгон баян” ХХК-тай байгуулсан гэрээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын даргын 2023 оны А/17, А/20 дугаар тушаалууд, “Их номгон баян” ХХК-тай байгуулсан гэрээг нөхөн байршуулах албан шаардлагыг хүргүүлэв.

3. Тайлант хугацаанд албан хаагч, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдэд олгосон цалин, урамшууллын дүнг Нийгмийн даатгалын тайланд 1,730.1 мянга, Хувь хүний орлогын албан татварын тайланд 3,906.5 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх “Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх “Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын албан хаагчид, комиссын гишүүдэд олгосон цалинг Нийгмийн даатгалын тайлан, Хувь хүний орлогын албан татварын тайланд залруулж мэдээлэх албан шаардлагыг хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумдын албан хаагчдын цагийн бүртгэлийг санхүүгийн баримтад бүрэн хавсаргаагүй, цалингийн бүртгэлээр хоцорсон цагийг бүртгэсэн байхад цалинг хасаж олгоогүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.1 дэх “Ажил олгогч хуульд өөрөөр заагаагүй бол үндсэн цалинг ажлын байрны шинжилгээ, үнэлгээ, эсхүл ажилтны ур чадварт үндэслэн цагаар, хийснээр, бусад хэлбэрээр тооцно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл,

үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Албан хаагчдын цагийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 04 дүгээр сарын 20, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох албан хаагчдад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хэлтсийн барилгыг ирэх онд шинээр барихтай холбоотой цэвэр бохир ус, халаалт, холбоо, эрчим хүчний техникийн нөхцөл гаргуулах зардалд 3,488.0 мянган төгрөгийг олгож, бараа материалд бүртгэн УСНББОУС-ыг зөрчсөн байна.	1	3,488.0			1	3,488.0	1	3,488.0				
Тайлант онд акталсан бараа материалын шийдвэрийг 2024 оны 02 дугаар сард гаргасан байна.	1	9,959.8			1	9,959.8	1	9,959.8				
ДҮН	2	13,447.8	0	-	2	13,447.8	2	13,447.8	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэгт нягтлан бодогчийг томилсон, тооллогын бүртгэл хийсэн ажлын баримт хангалтгүй, тооллогын дүнг баталгаажуулсан тушаал гаргаагүй байна.	1	24,205.4			1	24,205.4						
Тайлант хугацаанд байгууллагын албан хаагч, ЭХМК-ын гишүүдэд олгосон цалин, урамшууллын дүнг Нийгмийн даатгалын мэдээнд 1,730.1 мянга, татварын мэдээнд 3,906.4 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн байна.	1	5,636.5			1	5,636.5						
Сумдын албан хаагчдын цагийн бүртгэлийг санхүүгийн баримтад бүрэн хавсаргаагүй, цалингийн бүртгэлээр хоцорсон цагийг бүртгэсэн байхад цалинг хасаж олгоогүй байна.	1	-					1	-				
Дүн	3	29,841.90	0	-	2	29,841.90	1	-	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын даргын хөрөнгө зарцуулах 39,782.0 мянган төгрөгийн 2 тушаал, тайлант онд байгуулсан 1 гэрээг байршуулаагүй байна.	1	39,782.0	0	0	1	39,782.0	0	0
Дүн	1	39,782.0	0	0	1	39,782.0	0	0

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 250 /1/ АОСБ 0258/2024
2024/40/А -СТА -ТУС

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын дарга хэлтсийн үндсэн хөрөнгө, бараа материалын 2023 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэгт үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогчийг томилсон, ажлын хэсгийн бэлтгэсэн тооллогын бүртгэл хийсэн ажлын баримт хангалтгүй, баримтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй, албан хаагчдын эд хөрөнгийн картыг шинэчлэн хөтөлж албажуулаагүй, эд хөрөнгийн тооллогын дүнг газрын даргын тушаалаар баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй: бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх", 72 дугаар зүйлийн 72.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна", 72.4 дэх "Тооллогын комисс дараах үүрэгтэй: комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн,

5040759

D/2024-ASH

хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.2 дахь “Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгийг нүд үзэн тоолж, баримтжуулан баталгаажуулах, албан хаагчдын эд хөрөнгийн картыг шинэчлэн албажуулж, тооллогын дүнг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн, газрын даргын тушаалаар баталгаажуулан зөрчлийг арилган, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан тухай нотлох баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Азжаргал, Санхүү, бүртгэлийн тэсгийн дарга, ахлах нягтлан бодогч С.Хонгорзул нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 251/2/АО560238/ВНА
2024/10/НА - СТА - ТМБ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын албан хаагч, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдэд олгосон цалин, урамшууллын дүнг Нийгмийн даатгалын мэдээнд 1,730,119 (Нэг сая долоон зуун гучин мянга нэг зуун арван есөн), төгрөг, Татварын мэдээнд 3,906,451 (Гурван сая есөн зуун зургаан мянга дөрвөн зуун тавин нэгэн) төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх “Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх “Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан

5040790

D/2024-ASH

шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын албан хаагчид, комиссын гишүүдэд олгосон цалинг Нийгмийн даатгалын мэдээнд 1,730,119 (Нэг сая долоон зуун гучин мянга нэг зуун арван есөн), төгрөг, Татварын мэдээнд 3,906,451 (Гурван сая есөн зуун зургаан мянга дөрвөн зуун тавин нэгэн) төгрөгөөр залруулж зөрчлийг арилган, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан тухай нотлох баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Азжаргал, Санхүү, бүртгэлийн тэсгийн дарга, ахлах нягтлан бодогч С.Хонгорзул нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 2024/3/А0560238/БАА
2024/40/АА-СТА -ТМЗ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын нягтлан бодогч байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын даргын хөрөнгө зарцуулах тухай 39,782,808 (Гучин есөн мянга долоон зуун наян хоёр мянга найман зуун найман) төгрөгийн А/17, А/20 дугаар тушаалууд болон тайлант онд “Их Номгон баян” ХХК-тай байгуулсан гэрээг байршуулаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа,

5040765

D/2024-ASH

зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 39,782,808 (Гучин есөн мянга долоон зуун наян хоёр мянга найман зуун найман) төгрөгийн A/17, A/20 дугаар тушаалууд, тайлант онд “Их Номгон баян” ХХК-тай байгуулсан гэрээг нөхөн мэдээлж, нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 04 дугаар сарын 19-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Азжаргал, санхүү, бүртгэлийн тэсгийн дарга, ахлах нягтлан бодогч С.Хонгорзул нарт даалгав^{2,3}.


АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны A/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно